

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 25 /12

Улаанбаатар хот

Компанийн бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.13, 76.1.18, Компанийн дүрмийн 8.12.13, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2025 оны 05-р сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Комплайнсын хяналтын заавар”-ийг Хавсралт № 1-р баталсугай.
2. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг”-ийг Хавсралт № 2-р баталсугай.
3. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг Хавсралт № 3-р баталсугай.
4. Бодь Даатгал ХК-д дагаж мөрдөх “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ийг Хавсралт № 4-р баталсугай.
5. Компанийн Гүйцэтгэх захирал болон холбогдох албан тушаалтуудад батлагдсан дүрэм, журм, бодлогыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
6. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор Ш.Бэжидэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



Б.БИЛЭГТ

БОДЬ ДААТГАЛ ХК-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн
25/12 тоот тогтоолын хавсралт *4*



Бодь даатгал ХК	
Баримт бичгийн төрөл:	Журам, заавар
Журам:	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
Боловсруулсан нэгж:	Дотоод хяналтын алба
Хэрэгжүүлэх нэгж:	Бүх газар нэгж
Хэрэгжилтэд хяналт тавих нэгж:	Дотоод аудит
Нууцын зэрэг:	/В/ Компанийн дотоод хэрэгцээнд нууц биш
Журмын дугаар:	
Хүчинтэй хугацаа:	Эхлэх: ТУЗ-ийн тогтоол гарснаар Дуусах: ТУЗ-ийн тогтоол хүчингүй болсонд тооцох хүртэл
Хуудасны тоо:	9

	Нэр	Албан тушаал	Гарын үсэг
Бэлтгэсэн:	Д.Наранцэцэг	ДХХХ-ийн ажилтан	
Санал өгсөн:	Ш.Бэжид Л.Банзрагч А.Энхжаргал М.Мөнхбаатар	ТУЗ-ын гишүүн ТУЗ-ын хараат бус гишүүн Гүйцэтгэх захирал БХГ-ын захирал	
Баталсан:	Б.Билэгт	ТУЗ-ын дарга	
Баталсан огноо:	2025.05.14	Ангилал:	Дотоодын хэрэгцээнд

ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Журмын дугаар	Батлагдсан огноо/ тушаалын дугаар	Нэмэлт, өөрчлөлт орсон огноо/ тушаалын дугаар	Цуцлагдсан огноо/ тушаалын дугаар
1				
2				
3				



БОДЬ ДААТГАЛ ХК-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ НЭГ. ЗОРИЛГО

- 1.1 Энэхүү журмыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.4.4 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Компанийн засаглалын кодексын хүрээнд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү журмын зорилго нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, тэдгээрээс компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.3 Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ бүртгүүлсэний дараа ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон бол энэ Журамд заасан эрх бүхий албан тушаалтанд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 1.4 Мэдүүлэг гаргагч нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц, нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар хийж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

ХОЁР. ЖУРАМД ГАРАХ ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1 **Эрх бүхий албан тушаалтан:** Компанийн нийт гаргасан хувьцааны 20 болон түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд болон ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын орлогч, газрын захирлууд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог Компанийн дүрмээр тодорхойлсон удирдах албан тушаалтан, ерөнхий нягтлан бодогч эсхүл тухайн чиг үүргийг гүйцэтгэдэг албан тушаалтнууд;
 - 2.1.2 **Ашиг сонирхлын зөрчил:** Компанийн эрх бүхий албан тушаалтан хууль болон гэрээгээр олгогдсон эрхээ хэрэгжүүлэх явцад түүний хувийн ашиг сонирхол Компанийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ үнэнч, шударгаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдал;
 - 2.1.3 **Компанийн ашиг сонирхол:** Компанийн эрхэмлэх зүйлс, баримтлах зарчим, стратеги, тушаал шийдвэр, компанид мөрдөгдөж байгаа бүхий л дүрэм, журам, заавар, аргачлалд нийцсэн эдийн болон эдийн засгийн бус ашиг сонирхол;
 - 2.1.4 **Хувийн ашиг сонирхол:** Ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцад өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхол;
 - 2.1.5 **Эрх бүхий албан тушаалтнуудтай нэгдмэл сонирхолтой этгээд:** Компанийн тухай хуулийн 89.2.1, 89.2.2, 89.2.3-т заасан хэлбэрээр холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;
 - 2.1.6 **Нэгдмэл сонирхлын мэдүүлэг:** Ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй этгээдүүд, тэдгээрийн талаар Компанийн эрх бүхий албан тушаалтны гаргаж өгсөн

мэдээллийг хэлэх ба Журмын 3 дугаар хавсралт “Нэгдмэл сонирхолтой этгээдийг бүртгэх хуудас”-аар бүртгэнэ;

2.1.7 Сонирхлын зөрчилтэй хэлцэл: Энэхүү журмын 2.1.1, 2.1.5-д заасан этгээдүүдээс компанитай хийх хэлцэлд Компанийн тухай хуулийн 89.1.1-89.1.4-д заасан хэлбэрээр холбоотой хувь хүн, хуулийн этгээдтэй хийсэн хэлцлийг;

ГУРАВ. МЭДҮҮЛЭГ ГАРГАХ

- 3.1 Энэхүү журмын 2.1.1-д заасан албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэх талаараа Компанийн тухай хуулийн 91.1.1-91.1.4-т заасан мэдээллийг, мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тус тус ТУЗ-ийн нарийн бичгийн даргад уг албан тушаалд томилогдсон, мэдээлэлд өөрчлөлт орсон өдрөөс хойш 10 хоногийн дотор 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу мэдүүлэх үүрэгтэй.
- 3.2 Энэхүү Журмын 3.1-д заасан мэдүүлгийг үнэн зөвөөр мэдээлээгүй, хугацаа хожимдуулж мэдээлсэн, мэдүүлэгт дурдсан мэдээлэлд өөрчлөлт орсон талаар мэдээлээгүйгээс компанид аливаа хохирол учирсан тохиолдолд буруутай этгээд зохих хариуцлага хүлээж учирсан хохирлыг арилгах үүрэгтэй.
- 3.3 Мэдүүлгийг бүртгэн хүлээн авч буй албан тушаалтан уг мэдээллийг компанийн гэрээ хэлцэл хийх үед холбогдох этгээдэд мэдээлэх үүрэгтэй.

ДӨРӨВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ

- 4.1 Сонирхлын зөрчилтэй хэлцлийг ердийн журмаар Гүйцэтгэх захирлын хүрээнд дангаар шийдвэрлэхгүй.
- 4.2 Гүйцэтгэх захирал нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-д танилцуулж зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр хийнэ. Зөвшөөрөл аваагүй хийгдсэн аливаа хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.
- 4.3 Гүйцэтгэх захирлын зөвшөөрөл авах танилцуулгад дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - 4.3.1 Хэлцлийн хүрээнд нийлүүлэх болон худалдан авах зүйлийн нэр, хэмжээ, нийлүүлэх болон худалдан авах хугацаа;
 - 4.3.2 Хэлцэлд оролцогч нөгөө талын нэр, компани болон энэ журмын 2.1.1-д заасан этгээдтэй ямар холбоотой болохыг тодорхойлсон тодорхойлолт;
 - 4.3.3 ТУЗ-өөс гарах шийдвэрийн төсөл;
- 4.4 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар гаргана. Хэрэв шийдвэр гарч чадаагүй тохиолдолд уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж уг хуралд оролцсон сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхоор шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Журмын 1 дүгээр хавсралтаар “Сонирхлын зөрчилтэй хэлцэл бүртгэх хуудас”-аар бүртгэнэ;
- 4.5 Энэхүү журмын 2.1.1-д заасан этгээд нь өөрийн болон өөртэй нь нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийх хэлцлийг шийдэх ажиллагаанд аливаа байдлаар оролцохыг хориглоно.
- 4.6 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг жилийн тайланд Компанийн тухай хуульд заасны дагуу тусгах замаар нийтэд мэдээлнэ.

- 4.7 Жилийн тайланд сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:
- 4.8.1 Хэлцлийн хүрээнд авах болон худалдах зүйлийн нэр, хэмжээ;
 - 4.8.2 Хэлцлийн үнэ;
 - 4.8.3 Хэлцэлд оролцогч нөгөө талын нэр;
 - 4.8.4 Хэлцэлд оролцогч нөгөө талын компани болон компанийн эрх бүхий албан тушаалтантай холбоотой байдал.

ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

- 5.1 Энэхүү журамд ТУЗ-ийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд журмын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажиллана
- 5.2 Уг журамд тусгаагүй аливаа харилцааг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан бусад дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.
- 5.3 Энэхүү журам батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Хавсралт 1

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БҮРТГЭХ ХУУДАС

1. Группийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Группийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол “Сонирхлын зөрчилтэй хэлцэл”-д тооцож бүртгэнэ.
 - Хэлцлийн нөгөө тал эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
 - Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн албан хувьцааны /ноогдол хувийн/ 20-иос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцаа /ноогдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

№	Хэлцлийн мэдээлэл				Сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох хуулийн үндэслэл
	Хэлцлийн нөгөө тал	Хэлцлийн нэр	Огноо	Хэлцлийн дүн	
1					
2					
3					

2. ХЭХ болон ТУЗ-ийн хурлын сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосон тогтоол, шийдвэрийн эх хувийг энэхүү бүртгэлийн хавсралтаар хадгална.

Хавсралт-2

“СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЭТГЭЭДИЙН МАЯГТ”

Бодь даатгал ХК /цаашид “Компани”/-тай.....зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх бүхий албан тушаалтан /ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, энгийн хувьцааны 20-иос дээш хувийг эзэмшигч/.....овогтой.....-ны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт.

Миний бие Монгол Улсын Компани тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1 дэх хэсэгт заасныг үндэслэн өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг Компаний тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2, 91 дүгээр зүйлийн 91.1 болон 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт зааснаар хүргүүлж байна. Үүнд:

- 1 Эхнэр/нөхөр:
- 2 Хүү/охин:
- 3 Ач/зээ:
- 4 Аав/ээж:
- 5 Ах, эгч, дүү:
- 6 Бусад төрөл, садангийн хүн:
- 7 Мийний бие болон дээр дурдсан хүн/ хүмүүсийн хяналтын багцыг эзэмшдэг хуулийн этгээд:
.....
.....
- 8 Миний бие болон дээр дурдсан хүн/ хүмүүсийн албан тушаал:
.....
.....

Цаашид надтай нэгдмэл сонирхолтой дээрх хүмүүс, хуулийн этгээд болон түүний охин компанитай гэрээ хэлцэл хийх тохиолдолд тухай бүр Компанийн ТУЗ-д мэдээлж байх болно.

Гарын үсэг.....

Огноо: ...оны ...сарын... өдөр

Хавсралт 3

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ ХУУДАС

1. Групптэй дараах хамааралтай этгээдийг “Нэгдмэл сонирхолтой этгээд”-д тооцож бүртгэнэ. Үүнд:
 - 1.1. Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн группийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;
 - 1.2. Группийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд группийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;
 - 1.3. Группийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/
 - 1.4. Нэг гэр бүлийн гишүүн, эцэг эх, хүүхэд, ач зээ нар, ах дүү, бусад төрөл, садны хүн;
 - 1.5. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан;
 - 1.6. Нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч;

№	Нэр	Нэгдмэл сонирхолтойд тооцогдох хамаарал	Хувьцааны хамаарал		
			Төрөл	Тоо	Эзэмшил хувь
1					
2					
3					

2. Нэгдмэл сонирхолтой этгээд нь нэгдмэл сонирхолтой этгээдэд тооцогдох хамаарал нэмэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдолд тус үйл баримтын талаар Группт ажлын 5 хоногийн дотор мэдэгдэнэ.